

## **Оролцогчдод зориулсан мэдээллийн хуудас**

Тэнэгрэлийн тухай хандлага: Дэлхийн Алцегеймарын тайлан 2019 судлагаа

Энэхүү Алцегеймарын болон бусад төрлийн тэнэгрэлийн талаархи хандлага, итгэл үнэмшлийг судлах судлагаанд оролцох гэж байгаад тань талархал илэрхийлж байна. Энэхүү мэдээллийн хуудас нь та судлагаа өгөхөөр шийдсэн бол оролцогчийн хувьд судалгааны зорилго, таны оролцоо, эрхийн талаар мэдээлэл өгнө.

### **1. Судлагаа юуны талаар вэ?**

Бид Алцегеймар өвчний олон улсын байгууллагын хувьд (ADI) тэнэгрэлийн тухай хандлага, итгэл үнэмшлийн тухай дэлхийн хамгийн том судлагаа хийхийг хүсч байна. Иймд бид тэнэгрэлтэй хүмүүс, тэдний асран хамгаалагчид, эрүүл мэндийн ажилтнууд, олон нийтээс мэдээлэл цуглуулахыг хүсч байна.

Энэ сэдвээр ойлголтыг илүү болгохын тулд дэлхийн хот, хөдөөгийн олон төрлийн олон нийтийн бүлгээс мэдээлэл авч байна. Дараа нь бид үр дүнгүүдийг нэгтгэн тайлан гаргаж олон нийт авах боломжтойгоор түгээнэ.

### **2. Би оролцох хэрэгтэй юу?**

Оролцох эсэх нь таны шийдвэрээс шалтгаална. Та хүсэхгүй бол оролцохгүй байж болно. Хэрвээ оролцохоор шийдсэн бол таныг судалгаа эхлэхээс өмнө зөвшөөрлийн хуудсыг бөглөхийг хүсч байна.

### **3. Миний оролцоо ямар байх вэ?**

Тэнэгрэл, алцегеймарын өвчинтэй холбоотой холбоотой асуултад хариулна. Таньд онлайнаар эсвэл хүснэгтэд өгөгдсөн асуултад хариулах юм. Судалгаа 10-15 минут болно.

### **4. Та судлагаанаас хэзээ гарч болох вэ?**

Шалтгаангүйгээр судалгааны аль ч шатанд гарч болно. Ямар нэг асуулт таатай бус санагдвал хариулахгүй байж болно. Судлагаанаас гарах нь таньд ямар нэг байдлаар нөлөөлөхгүй.

### **5. Миний мэдээлэл юунд ашиглагдах вэ?**

Бид судалгааны үр дүнг 2019 оны тэнэгрэл, алцегеймарын тайланд илтгэнэ. Таны мэдээлэл ямар ч тайлан, хэвлэл, харилцаанд харагдахаар гарахгүй.

### **6. Миний мэдээлэл нууцлалтай байж чадах уу? Тодорхой нэргүй байх уу?**

Тийм. Таны талаар цуглуулсан мэдээлэл маш сайн нууцлагдана. Бүх мэдээлэл тодорхой нэргүй, зөвхөн судлаачид мэднэ. Мэдээлэл дижитал хэлбэрээр код

өгч, оролцогчийн ямар нэг нэр, хайггүй хадгална. Судлагааны цаасан мэдээллийг нууцалсан файлд хадгална.

**7. Судлагаанд оролцсоноор ямар үр шим хүртэх вэ?**

Таньд шууд ямар нэг үр шим өгөхгүй боловч удаан хугацаанд тэнэгрэлтэй амьдарч байгаа хүмүүсийг ялгаварлан гадуурхахаас сэргийлэх хөтөлбөр боловсруулахад шаардлагатай чухал мэдээллийг судалгаанаас авах юм.

**8. Судалгаанд оролцсоны давуу тал, эрсдэл байна уу?**

Тийм зүйлийг бид энэ судалгаанаас хүлээгээгүй. Таны хандлага, итгэл үнэмшлийг асууж байгаа учраас таньд эвгүй байж магадгүй. Ийм учраас таньд таагүй сэтгэгдэл төрж байвал судалгаанаас гарч болно.

**9. Таньд асуулт, гомдол байвал яах вэ?**

Таньд ямар нэг асуулт байвал Wendy Weidner-тай дараах хаягаар холбогдож болно: [w.weidner@alz.co.uk](mailto:w.weidner@alz.co.uk)

**Та судалгаа өгөхөөр шийдсэн бол зөвшөөрлийн хуудсыг бөглөөрэй.**